



ДУНДГОВЬ АЙМАГ  
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/197

Сангиндалай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн  
зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-ийн 25 дугаар зүйлийн 25.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, газар дээр нь танилцах, судалгаа хийх, илэрсэн зөрчлийг арилгуулах, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэхэд арга зүйн зөвлөгөө өгөх зорилго бүхий зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Сумын Засаг даргын орлогч  
Нарийн бичгийн дарга: Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн-1  
Гишүүд: Засаг даргын Тамгын газрын дарга  
Эрүүл мэндийн төвийн дарга  
Ерөнхий боловсролын сургуулийн захирал  
Цэцэрлэгийн эрхлэгч  
Соёлын төвийн дарга  
Эрэн хайх, аврах салбарын дарга  
Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн-2  
Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч  
Жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн ажлын төлөвлөгөөг боловсруулан, батлуулж, хэрэгжилтийг хагас бүтэн жилээр тооцон тайлагнахыг зөвлөлийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/34 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ЛХАГВАМАНДАЛ

482302193